Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугаар
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

**БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ**
**"ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"**

<table>
<tr><th>№</th><th>Үзүүлэлт</th><th colspan="2">Шалгуур үзүүлэлт</th><th>Авбал зохих оноо</th><th>Оноо[1]</th><th>Хувийн жин[2]</th></tr>
<tr><td>1</td><td>2</td><td colspan="2">3</td><td>4</td><td>5</td><td>6</td></tr>
<tr><td>1</td><td rowspan="6">Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)</td><td colspan="2">Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]</td><td>1</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>2</td><td colspan="2">Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]</td><td>1</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td rowspan="4">3</td><td rowspan="4">Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал</td><td>Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]</td><td>0,5</td><td>0.5</td><td>0.5</td></tr>
<tr><td>Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]</td><td>0,5</td><td>0.5</td><td>0.5</td></tr>
<tr><td>Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]</td><td>0,5</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td>Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]</td><td>0,5</td><td>0.5</td><td>0.5</td></tr>
<tr><td colspan="4">Хэсгийн оноо</td><td>4</td><td>2.5</td><td>2.5</td></tr>
<tr><td>4</td><td rowspan="3">Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)</td><td colspan="2">Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] (гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)</td><td>1</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>5</td><td colspan="2">Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]</td><td>1</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td>6</td><td colspan="2">Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]</td><td>1</td><td>0</td><td>0</td></tr>
<tr><td colspan="4">Хэсгийн оноо</td><td>3</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>7</td><td rowspan="3">Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)</td><td colspan="2">Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]</td><td>1</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>8</td><td colspan="2">Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] (Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)</td><td>1</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td>9</td><td colspan="2">Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]</td><td>1</td><td>1</td><td>1</td></tr>
<tr><td colspan="4">Хэсгийн оноо</td><td>3</td><td>3</td><td>3</td></tr>
<tr><td colspan="4">Үнэлгээний нийт оноо, хувь</td><td>10</td><td>6.5</td><td>6.5</td></tr>
<tr><td colspan="4"></td><td colspan="2">Эзлэх хувь (%)</td><td>65</td></tr>
</table>

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

**Тайлбар:**

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.
[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.
[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор баталсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн баталсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.
[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.
[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.
[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.
[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.
[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

Ёс зүйн хорооны 2025 оны 12 дугээр
сарын 01-ний өдрийн 09 дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
“ТАЙЛАНГИЙН МАЯГТ”[1]

**НЭГ. Товч танилцуулга[2]**

- Монгол Улсын Үндэсний номын сангийн дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь 5 хүний бүрэлдэхүүнтэй байгууллагын хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн ба энэ хугацаанд гомдол, мэдээлэл ирээгүй.

**ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар**

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

- Үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг тусгасан.
- Ёс зүйн сургалтыг 2 удаа танхимаар зохион байгуулсан.
- Соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил 1 удаа цахимаар зохион байгуулсан.

2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:

- Гомдол ирээгүй.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг олон нийтэд нээлттэй байршуулаагүй.
- 2025 оны 12 дугаар сарын 10 өдрийн Дугаар 05 “Монгол Улсын ерөнхий сайдын албан даалгавар”-ыг үндэслэн Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшуулал олгогдоогүй.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

- Төрийн албаны “ХНУМТ” цахим системд гишүүдийн бүртгэл, төлөвлөгөө, тайланг цаг хугацаанд нь шивж оруулсан.
- Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан ЁЗДХ-ны гишүүдийг чадавхижуулах сургалтанд 1 удаа цахимаар, 2 удаа танхимаар бүх гишүүд хамрагдсан.
- Байгууллагын фэйсбүүк группт 7 удаа, Ёс зүйн дэд хороодын нэгдсэн группт 1 удаа мэдээлэл оруулж, 10 материалаар нийт ажилчдад “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг суртчилан таниулж ажилласан.
- Ёс зүйн дэд хорооны 1 гишүүний нөхөн сонгууль цахимаар явуулж, 1 удаа сургалтын төсөв батлуулан, 2 удаа албан бичиг явуулж, 2 удаагийн нэгдсэн сургалт танхимаар зохион байгуулсан.
- Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.
[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.
[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

| |
|---|
| - 2025 онд Ёс зүйн дэд хороонд өргөдөл, гомдол ирээгүй болно. |

| Гарсан үр дүн, ололт амжилт: | Бэрхшээл: |
|---|---|
| - Танхимын сургалтад давхардсан тоогоор нийт 89 албан хаагч хамрагдаж, Ёс зүйн тухай хууль, тогтоомж, дүрэм журмын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлсэн.<br>- Мөн "Шинээр батлагдсан журам, шийдвэрийн танилцуулга" болон "Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээний талаарх ойлголтыг нэмэгдүүлсэн. | - Төрийн үйлчилгээний албан хаагчид ажлын цагийн ачааллаас шалтгаалан ёс зүйн сургалтад 100 хувь бүрэн хамрагдах боломжгүй. Жич: Үйлчилгээний байгууллага учраас |

| Санал: |
|---|
| - Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийн ёс зүйн чиглүүлэх сургалтыг нэгдсэн байдлаар зохион байгуулах<br>- Төрийн албан хаагчдыг ажлын цагаар үйлчилгээг түр зогсоон сургалтад хамрагдах боломж нөхцлөөр албан ёсоор хангах<br>- Ёс зүйн дэд хорооны гишүүдийн урамшууллыг олгох, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх |

**Шалгах хэсэг:**

☑ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.

☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.

☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

**БАТАЛГААЖУУЛАЛТ:**

Томилох эрх бүхий албан тушаалтан

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/ Б.Мөнх-Эрдэнэ

Ёс зүйн дэд хорооны дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

/Албан тушаал/ /Гарын үсэг/ /Гарын үсгийн тайлал/ Д.Баярсайхан

Огноо: 2026 оны 01 сарын 12